

Зээлийн багц гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зээлийн гэрээ байгуулах тухай

“Говь” ХК нь “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниудтай хамтран “Голомт” Банктай байгуулсан зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, тус зээлийн багц гэрээний хүрээнд нэмэлт зээлийн гэрээ байгуулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК, “Таван Богд” ХХК, “Улаанбаатар Гурил” ХХК, “Ю Би Пи” ХХК, “Таван Богд Интернэйшнл” ХХК, “Эйрлинк Монголиа” ХХК, Таван Богд Моторс” ХХК, “Таван Богд Нура” ХХК -иудын хамт Голомт Банктай байгуулсан 2018 оны 03-р сарын 19-ний өдрийн ЗББГС210207652/GNPLT тоот Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн гэрээний хугацааг 27 /хорин долоон/ сараар сунгах,
 - 1.2. Хугацааны эцэст буюу 2028 оны 03-р сарын 19-ний өдөр эргэн төлөх,
 - 1.3. Эрхийн хэмжээг 33,000,000,000 /гучин гурван тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлэн 135,000,000,000 /нэг зуун гучин таван тэрбум/ төгрөг хүртэл буюу түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаас хэтрэхгүй байх болгон нэмэлт өөрчлөлт оруулах,
 - 1.3.1. Дээрх нэмэгдүүлж буй эрхийн 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөгийг “Улаанбаатар Гурил” ХХК нь хөнгөлөлттэй зээлээр ашиглах,
 - 1.3.2. Зээлийн шугамаар ашиглах 115,000,000,000 /нэг зуун арван таван тэрбум/ төгрөгийн 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөгийн эрхийг барьцаа хөрөнгөөр хангуулсны дараа зээлийн шугамын зориулалтаар ашиглах,
 - 1.4. Ам.долларын шугамын зээлийн хүүг 9.0 /есөн/ хувь болгон бууруулах,
 - 1.5. Ам.долларын хүүний нөхцөлөөс бусад нөхцөлийг өмнөх гэрээнд заасны дагуу хэвээр үлдээхийг зөвшөөрсүгэй, Үүнд: Төгрөгийн хүү, аккредитив, баталгааны хүү, зээл олголтын шимтгэл, нөөцлөн баталгаажуулсны шимтгэл,
 - 1.6. “Таван Богд Холдингс” ХХК нь 100.0%-ийн хувьцаа эзэмшдэг охин компани “Таван Богд Моторс” ХХК-ийг Зээлийн эрх нээх гэрээний хамтран зээлдэгчээс хасах,
 - 1.7. Гэрээний 7.1-д заасан “Санхүүгийн харьцаа үзүүлэлт”-ийг Группийн хэмжээнд тооцохоор дараах байдлаар өөрчлөх,
 - 1.7.1. Өрийн үйлчилгээний харьцаа > 1.0
 - 1.7.2. Өр төлбөр/ Нийт актив $< 60\%$
 - 1.7.3. Эргэлтийн харьцаа > 1.2
 - 1.8. Гэрээний 7.2-д заасан “Санхүүгийн харьцаа үзүүлэлт”-ийг дараах байдлаар өөрчлөх,
 - 1.8.1. “Таван Богд Фүүдс” ХХК-ийн Голомт банкны ПОС төхөөрөмжөөр хийдэг картын төлбөр тооцооны хэмжээ нь нийт нийт картын төлбөр тооцооны 50.0 /тавин/ хувиас дээш хувийг эзэлж байх,



2025 он 12 сар 17 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

- 1.8.2. “Говь” ХК-ийн Голомт банкны ПОС төхөөрөмжөөр хийдэг картын төлбөр тооцооны хэмжээ нь нийт нийт картын төлбөр тооцооны 70.0 /далан/ хувиас дээш хувийг эзэлж байх,
2. Дээрх зээлийн багц гэрээний хүрээнд “Улаанбаатар Гурил” ХХК-ийн “Голомт Банк”-тай байгуулж буй “Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийг дараах нөхцөлөөр авахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
- 2.1. Зээлийн хэмжээ: 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөг
- 2.2. Зээлийн хугацаа: 24 /хорин дөрвөн/ сар
- 2.3. Төгрөгийн зээлийн хүү жилийн: 17.0 /арван долоон/ хувь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн 12.0 /арван хоёр/ хувь,
3. Дээрх зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.
4. “Улаанбаатар Гурил” ХХК-ийн хөнгөлөлттэй зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №2-д заасан хөрөнгүүдийг нэмэлтээр барьцаалахыг зөвшөөрсүгэй.
5. Дээрхээс бусад гэрээний нөхцөлүүд хэвээр хадгалагдахыг зөвшөөрсүгэй.
6. Дээрх Зээлийн багц бүтээгдэхүүний нэмэлт гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ